



I-X/2021


Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 15



## Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 16.8 хувиар өслөө

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 15.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 (17.0%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.4 (15.8%) их наяд төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 655.3 (22.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 118.1 (12.4%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэл 24.2 (21.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 2021 оны 10 дугаар сард 1.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 241.4 (16.8%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 195.8 (20.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны 10 дугаар сард 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 250.0 (17.7%) тэрбум төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 374.0 (63.2%) тэрбум төгрөг, газрын тос олборлолт 6.8 (11.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2021 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төмрийн хүдэр, зэсийн баяжмал, хүрэн нүүрс, газрын тос олборлолт өмнөх оны мөн үеэс 2.4 – 40.6 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт ус, ундаа, жүүс, малын мах, гар

ариутгагч, цемент, катодын зэс (99%), согтууруулах ундаа, шохой, шингэн сүү, нүүрсэн шахмал түлш, янжуур тамхи, баяжуулсан нүүрс, металл бэлдэц зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.2 – 94.9 хувиар өссөн байна.

#### ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2020		2021*		2021* I-X
		Х	I-X	Х	I-X	2020 I-X
						хувь
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>						
Чулуун нүүрс	мян.т	5 750.3	24 680.6	1 874.3	19 617.0	79.5
Хүрэн нүүрс	мян.т	697.6	5 024.2	659.8	5 628.5	112.0
Газрын тос	мян.баррел	571.5	3 017.4	284.8	4 243.6	140.6
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	мян.т	109.6	1 051.1	119.0	1 115.1	106.1
Цэвэршүүлээгүй алт	кг	2 357.7	17 237.9	2 170.8	16 249.9	94.3
Төмрийн хүдэр	мян.т	1 047.3	7 813.7	988.9	7 999.6	102.4
Хайлуур жонш	мян.т	9.3	109.4	7.4	104.4	95.4
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>						
Малын мах	т	4 768.1	18 602.8	2 103.6	19 180.9	103.1
Шингэн сүү	мян.л	3 649.6	36 774.7	4 414.9	44 205.5	120.2
Гурил	мян.т	22.8	176.5	20.4	174.4	98.8
Цэвэр спирт	мян.л	1 147.4	9 084.5	984.4	8 691.4	95.7
Согтууруулах ундаа	сая л	12.5	104.2	10.2	110.4	106.0
Ус, ундаа, жүүс	сая л	28.9	274.9	14.4	280.8	102.2
Янжуур тамхи	мян.блок	216.5	1 718.1	313.3	3 026.9	176.2
Амны хаалт	мян.ш	690.2	12 340.6	1 034.3	8 796.8	71.3
Гар ариутгагч	мян.л	22.4	282.4	35.0	292.1	103.5
Ноолууран сүлжмэл эдлэл	мян.ш	138.8	1 246.1	80.3	389.5	31.3
Самнасан ноолуур	т	55.8	474.8	36.0	397.4	83.7
Баяжуулсан нүүрс	т	406.5	1 946.8	304.1	3 464.3	178.0
Нүүрсэн шахмал түлш	мян.т	69.4	360.1	57.7	549.2	152.5
Цемент	т	149.9	1 118.8	139.5	1 166.5	104.3
Шохой	т	9 207.2	64 168.8	8 460.5	73 017.9	113.8
Катодын зэс, 99%	т	879.7	7 753.1	694.7	8 194.3	105.7
Металл бэлдэц	т	164.6	15 277.6	3 309.0	29 778.4	194.9

Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хайлуур жонш, алт, чулуун нүүрсний олборлолт 4.6 – 20.5 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарт гурил, спирт, самнасан ноолуур, амны хаалт, ноолууран сүлжмэл эдлэл зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.2 – 68.7 хувиар буурсан байна.


Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2021 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 20.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.1 (32.8%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 4.5 (43.5%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	2020		2021*			2021* I-X
	Х	I-X	Х	I-X	гадаадад	2020 I-X
	тэрбум төгрөг					хувь
<b>Нийт дүн</b>	<b>2 404.3</b>	<b>15 488.2</b>	<b>2 352.8</b>	<b>20 572.4</b>	<b>12 969.1</b>	<b>132.8</b>
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1 761.9	10 287.9	1 709.5	14 761.9	11 953.8	143.5
Боловсруулах аж үйлдвэр	527.2	4 129.4	506.4	4 600.5	1 015.3	111.4
Цахилгаан хий, уур, агааржуулалт	103.0	958.0	119.1	1 071.0	-	111.8
Ус хангамж, сувагжилтын систем	12.2	113.0	17.8	139.0	-	123.0

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 4.5 (43.5%) их наяд төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 4.2 (60.4%) их наяд төгрөгөөр, газрын тос олборлолтын салбарынх 346.2 (2.2 дахин) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолтын салбарынх 87.7 (42.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

ЗУРАГ 2. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, тэрбум төгрөг



Гадаад зах зээлд 2021 оны эхний 10 сард 13.0 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн бөгөөд уул уурхайн бүтээгдэхүүний 73.7 хувийг металлын хүдэр олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 19.3 хувийг нүүрс олборлолтын салбар, 5.4 хувийг газрын тос олборлолтын салбарынх, 1.6 хувийг бусад ашигт малтмал олборлолтынх эзэлж, газрын тос олборлолтын салбарын бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар, металлын хүдэр олборлолт 8.2 нэгж хувиар тус тус өсөж, нүүрс олборлолтын салбарынх 9.0 нэгж хувиар, бусад ашигт малтмал олборлолтын салбарынх 0.5 нэгж хувиар тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (улирлын нөлөөллийг арилгасан тооцоо) 2021 оны 10 дугаар сард 172.3 (2015=100) болж, өмнөх оны мөн үеэс 23.0 хувиар өссөн байна.

## Ойлголт, тодорхойлолт

### **Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл:**

Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

### **Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн:**

Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

### **Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс:**

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёог ашиглан тооцно.

### **Тооцох аргачлал:**

Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёо:

$$I_{LQ} = \frac{\sum (Q_t \cdot P_0)}{\sum (Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum \left( \frac{Q_t}{Q_0} \right) \cdot W_0 \cdot 100$$

Q<sub>t</sub>- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ

Q<sub>0</sub>- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ

P<sub>0</sub>- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ

W<sub>0</sub>- Жин



### **Тайлбар:**

ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

### **Эх үүсвэр:**

ҮСХ, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

### **Ангилал, код:**

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал

### **Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

### **Дараагийн мэдээ тархах хуваарь: 2021 оны 12 дугаар сарын 15**

Эдийн засгийн статистикийн газрын

дарга А.Дэмбэрэл

Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө

аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн

статистикийн хэлтсийн статистикч

Б.Энхболд, Г.Цэвэлмаа

Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212